



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 365

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дах заалт, “Ази фарм” Хязгаарлагдмал Хувьцаат Компаниас ирсэн өргөдөл гомдлыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Ази фарм” Хязгаарлагдмал Хувьцаат Компаниас Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн зарласан Сурфактант эм худалдан авах тендер будлиантай болсон талаарх гомдлын дагуу тус газраас зарласан “Эм эмнэлгийн хэрэгсэл”-ийн ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагаа, эмийн худалдан авалт, зарцуулалтад дотоод аудит хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д үүрэг даалгасугай.

САЙД




Г.ШИЙЛЭГДАМБА

081299

Эрүүл мэнд спортын сайдын
2015 оны 09 сарын 17-өдрийн
365 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн



Ажлын хэсгийн дарга:

Э.Оюунсүрэн, Хяналт-Шинжилгээ, үнэлгээ
дотоод аудитын газрын дарга

Гишүүд

Б.Пүрэвсүрэн, Эмнэлгийн тусламж үйлчилгээний
бодлогын хэрэгжилтийн хяналт, шинжилгээ,
үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Г.Туул, Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

Д.Оюунтуяа, Эм эмнэлгийн хэргслийн
бүртгэлийн бодлогын хэрэгжилтийн
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Н.Энхбат, Авилга ашиг сонирхлын зөрчлөөс
урьдчилан сэргийлэх үйл, ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн

Д.Энхжаргал, Эм зүй, эм судлалын мэргэжлийн
салбар зөвлөлийн дарга

З.Гэрэлмаа, Хүүхдийн анагаахын мэргэжлийн
салбар зөвлөлийн гишүүн

Эрүүл мэнд спортын сайдын
2015 оны 09 сарын 17 өдрийн
365 дугаар тушаалын 2 дугаар
Хавсралт

Ажлын удирдамж

Нэг. Үндэслэл:

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дах заалтыг үндэслэсэн болно.

Хоёр. Зорилго:

Эрүүл Мэнд Спортын Яамны сайдын баталсан удирдамжийн хүрээнд “Ази фарм” ХХК-аас ирсэн өргөдөл гомдлын дагуу ЭХЭМҮТөвөөс зарласан “Эм эмнэлгийн хэрэгсэл”-ийн ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагаа, эмийн худалдан авалт, зарцуулалтад дотоод аудитыг хийж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Худалдан авах ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахаар гаргасан дүрэм, журам, “Төсвийн тухай” хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт заавар журам, норм, нормативын хэрэгжилтэнд үнэлэлт, дүгнэлт өгч, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, “Төсвийн тухай” хууль, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, хуулийн хэрэгжилт
- Худалдан авах ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахаар гаргасан дүрэм, журам
- Тендерийн чанарын үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн эсэх
- Тухайн байгууллагын “Эм эмнэлгийн хэрэгсэл”-ийн ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагаа, эмийн худалдан авалт, зарцуулалтанд дотоод аудитыг хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хамрах хүрээ:

ЭХЭМҮТөвийн тендерийн үнэлгээний хорооны үйл ажиллагаа хамрагдана.

Тав: Хугацаа:

Шалгалтыг 2015 оны 09 дүгээр сарын 16-аас ажлын 5 хоногт багтаан хийнэ.

Зургаа. Хүрэх үр дүн:

1. ЭХЭМҮТөвийн тендерийн үнэлгээний хорооны үйл ажиллагаанд дүгнэлт, зөвлөмж гаргана.
2. Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах.
 2. Цаашид дүгнэлтийг үндэслээд авах арга хэмжээ болон шийдвэрүүд гаргана.